

“КОРОНАВИРУСИЙН НӨЛӨӨЛЛИЙГ ТОДОРХОЙЛОХ ӨРХӨД СУУРИЛСАН СУДАЛГАА” –ГУРАВ ДАХЬ ШАТНЫ ҮР ДҮН

2021.01.18

Утсаар мэдээлэл цуглуулсан



МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ
СТАТИСТИКИЙН ХОРОО

КОРОНАВИРУСИЙН НӨЛӨӨЛЛИЙГ ТОДОРХОЙЛОХ ӨРХӨД СУУРИЛСАН СУДАЛГАА

- Коронавирусийн өрхөд үзүүлж буй нөлөөг “цаг тухайд нь” хянах зорилгоор Үндэсний статистикийн хороо (ҮСХ) болон Дэлхийн банк (ДБ) хамтран “Коронавирусийн нөлөөллийг тодорхойлох өрхөд суурилсан судалгаа”-г зохион байгуулж байна.
- Энэхүү танилцуулгаар 2020 оны 12 дугаар сарын 3-наас 15-ны хооронд зохион байгуулж мэдээлэл цуглуулсан судалгааны гурав дахь шатны үр дүнг нэгтгэн харуулсан болно.
 - Гурав дахь шатны судалгааны үр дүнг суурьшил (Улаанбаатар, аймгийн төв, сумын төв, хөдөө) болон хот, хөдөөг төлөөлөх чадвартай 1147 өрхийн мэдээлэлд үндэслэн тооцсон.
 - Энэ шатны үр дүнг өмнөх шатны судалгаануудын үр дүнтэй мөн харьцууллаа. Эхний шатны судалгааг 2020 оны 5 дугаар сарын 22-29, хоёр дахь шатны судалгааг 8 дугаар сарын 31-нээс 9 дүгээр сарын 7-ны өдөр зохион байгуулан явуулсан.
- Дөрөв дэх шатны судалгааг 2021 оны 2 дугаар сард зохион байгуулан явуулахаар төлөвлөж байна.

СУДАЛГААНЫ ХУГАЦАА БОЛОН ЗГ-ЫН АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭНИЙ ХАМААРАЛ

- Манай улс Коронавирусийн халдварын дэгдэлтээс урьдчилан сэргийлж 2020 оны 1 дүгээр сараас БНХАУ-тай харилцдаг хилийн хөдөлгөөнөө хаах, олон улсын нислэгээ цуцлах, сургууль, цэцэрлэгээ хаах зэрэг шуурхай, шийдэмгий арга хэмжээнүүдийг авч ирсэн. Гэхдээ дотооддоо хүмүүс ажиллах боломжтой хэвээр байв. Энэ өндөржүүлсэн бэлэн байдлыг 5 дугаар сарын 31-нээс сулруулж 9 дүгээр сарын 1-нд сургууль, цэцэрлэг хэвийн ажиллаж эхэлсэн.
- Гэвч Ковид-19 халдварыг дотооддоо алдсанаас шалтгаалан 11 дүгээр сарын 12-ноос бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжиж хөл хорио тогтоосон. Бүх нийтийн бэлэн байдлын үеэр зөвшөөрөгдсөн тодорхой тооны байгууллагын үйл ажиллагаанаас бусдыг бүгдийг зогсоосон. Бүх нийтийн бэлэн байдлыг 12 дугаар сарын 14-нөөс сулруулсан боловч сургуулиудыг хаах, олон нийтийг хамарсан үйлчилгээг хориглох зэрэг ихэнх хориг арга хэмжээнүүд хэвээр мөрдөгдөж байна. ⁽²⁾
- Гурав дахь шатны судалгааг бүх нийтийн бэлэн байдлын үед зохион байгуулан явуулсан бөгөөд хүн амын хөдөлгөөн маш их хязгаарлагдсан байв. Гурав дахь шатны судалгааны мэдээлэл цуглуулалт дуусах үед Ковид-19 халдварын батлагдсан тохиолдол 918 болсон байв.

ЗГ-ын хязгаарлалтын арга хэмжээ болон хүн амын хөдөлгөөний өөрчлөлтийг (Stringency индекс) судалгаа (КНТӨСС)-ны үе шатаар харьцуулж авч үзэх нь⁽¹⁾



Тэмдэглэл: (1) Oxford Stringency index гэдэг нь Ковид-19-ийн эсрэг ЗГ-ын авч хэрэгжүүлж буй хязгаарлалтын арга хэмжээний үр нөлөөг харуулдаг. "Google Ковид-19 Олон нийтийн хөдөлгөөний тайлан"-д хүмүүсийн өөр өөр газруудад очих давтамж болон тухайн газар байх хугацаа хэрхэн өөрчлөгдөж байгааг суурь үетэй харьцуулан (2020 оны 1 дүгээр сар) харуулсан.

(2) Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт 2020.12.23-наас 2021.01.06 хүртэл дахин шилжүүлсэн.

ҮНДСЭН ҮР ДҮН

- **Бүх нийтийн бэлэн байдал буюу хөл хорио хүн амын хөдөлмөр эрхлэлтийн байдалд ихээхэн нөлөө үзүүлсэн.**
 - Цар тахлаас өмнө ажил эрхэлж байсан ажиллагсдын 40 хувь нь хөл хорионы үе буюу гурав дахь шатны судалгааны үеэр ажил эрхлэхээ зогсоосон байжээ. Гэхдээ эдгээр ажил эрхлэхээ зогсоосон хүн амын 61 хувь нь хөл хорионы дараа ажилдаа эргэж орно гэж хариулсан нь хөл хорионоос шалтгаалан ажиллах хүч түр зуур зогсонги байдалд орсныг харуулж байна.
 - Гурав дахь шатны судалгааны үед ажил эрхлэхээ зогсоосон гэж хариулсан хүмүүсийн эзлэх хувь үйлдвэрлэлийн салбарт хамгийн өндөр (48%) дараа нь үйлчилгээний салбар (34%) болон хөдөө аж ахуйн салбарт (32%) байна.
 - Ажил эрхлэхээ зогсоосон хүн амыг хэрэглээний бүлгээр харахад онцын ялгаа байхгүй ч хамгийн бага хэрэглээтэй 40 хувийн ажиллагсдын дөрөвний нэг нь эхний шатны судалгааны үед ажил эрхлэхээ больсон байсан нь амьжиргаа муутай ажил эрхлэгч нар урт хугацаанд орлогын алдагдалд орсон байж болзошгүйг илтгэж байна.
- **Удаан хугацаанд үргэлжилсэн цар тахал, хөл хорио нь бизнесийн орчин, нөхцлийг маш ихээр муутгаж байна.**
 - Хувиараа бизнес эрхэлдэг гэж хариулсан өрхүүдийн 85 хувь нь хатуу хөл хорионы үеэр бизнесээ эрхлэх боломжгүй болжээ.
 - Орлого буурсан гэж хариулсан хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн 27 хувь нь бүр огт орлогогүй болсон гэж мэдээлсэн.
 - Өрхүүдийн бизнесийн алдагдал үргэлжлэх төлөвтэй байгаа ба хувиараа бизнес эрхэлж буй 3 өрх тутмын 2 нь ирэх гурван сард борлуулалтын орлого нь буурна гэсэн төсөөлөлтэй байна.
- **ХАА-н хөдөлмөр эрхэлдэг өрхүүдийн амьжиргаа сүүлийн хоёр шатны судалгааны хооронд мөн л дордсон байна.**
 - ХАА-н орлого нь буурсан гэж мэдээлсэн өрхүүдийн бараг 60 орчим хувь нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад орлого нь 40-өөс дээш хувиар буурсан гэж хариулсан байна. Гэтэл хоёр дахь шатны судалгааны үед тэдний 44 хувь нь орлогоо 40-өөс дээш хувиар буурсан гэж хариулж байв.
- **Бүх нийтийн бэлэн байдал буюу хөл хорионы үед цалинтай хөдөлмөр эрхлэгчдийн 30 орчим хувь нь ердийн үеийнх шигээ ажлаа хийх боломжгүй болсон ба тэдний тал нь цалингаа бүтнээр болон хэсэгчлэн авахаар байв.**

ҮНДСЭН ҮР ДҮН

- **Хүмүүс хөдөлмөр эрхлэх боломжгүй болж орлогын алдагдалд орж эхэлсэнтэй зэрэгцэн хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний үнэ нэмэгдэж байгаа нь амьжиргаа муутай иргэдийн хувьд хүнсний аюулгүй байдлыг нь улам бүр дордуулж байна.**
 - Ядуу өрхүүд (61%) ядуу бус (48%) өрхтэй харьцуулахад хүнсний бүтээгдэхүүний үнийн өсөлтөд илүү өртсөн байна.
 - Ядуу өрхүүдийн хүнсний аюулгүй байдлын асуудал нэмэгдсээр байна. Хангалттай, эрүүл, шим тэжээлтэй, олон төрлийн хоол хүнс олж авах чадвартаа эргэлзсээр байгаа ядуу өрхийн хувь хоёр дахь шатны судалгааны үед 39 хувь байсан бол энэ шатанд 47 хувь болж өссөн байна.
- **Нийт хүн амын хувьд коронавирүсээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаарх мэдлэг харьцангуй өндөр байгаа ба судалгаанд хамрагдсан 5 хүн тутмын 4 нь Ковид-19-ийн эсрэг баталгаатай вакциныг үнэ төлбөргүй хийлгэх хүсэлтэй байв.**
 - Гараа угаах (94%), маск зүүх (93%), гар барихаас зайлсхийх (97%), олон хүн оролцсон үйл ажиллагаанд оролцохоос татгалзах (96%) зэрэг халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор нийгмээс тусгаарлах арга хэмжээг бараг бүх хүн хүлээн зөвшөөрч, даган мөрдсөн байжээ.
 - Судалгаанд оролцогчдын 80 хувь нь вакциныг үнэ төлбөргүй бол хийлгэнэ, 61 хувь нь төлбөртэй байсан ч хийлгэнэ гэжээ. Вакцины баталгаатай байдалд эргэлзэх эргэлзээ хот, суурин газрын оршин суугчдын хувьд хөдөө амьдарч буй хүмүүстэй харьцуулахад илүү өндөр байна.
- **Бүх нийтийн бэлэн байдлын үе буюу хөл хорионы үед (3 дахь шатны судалгааны үе) эмнэлгийн үйлчилгээний хүртээмжтэй байдал тасалдсан байна.**
 - Эмчилгээ хийлгэх шаардлагатай байсан 3 хүн тутмын 1 нь эмнэлгийн үйлчилгээ авч чадаагүй бөгөөд үндсэн шалтгаан нь эмнэлгээс халдвар авах эрсдэлтэй гэж үзсэн болон гэрээс гадагш гарахыг хязгаарласан/хориглосоноос болсон байв. Гэтэл эхний шатны судалгааны үед эмчилгээ шаардлагатай болсон бараг бүх өрх (92%) эмнэлгийн үйлчилгээ авсан байна.
 - Хөл хорионы үед (зайн) боловсролын үйл ажиллагаа болон санхүүгийн үйлчилгээний хүртээмжид ноцтой тасалдал гараагүй байна.



СУДАЛГААНЫ ТАНИЛЦУУЛГА (ГУРАВ ДАХЬ ШАТНЫ МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАЛТ)


- **Мэдээлэл цуглуулалтын хугацаа (гурав дахь шат):** 2020.12.03-15
- **Түүврийн хүрээ:** 2018 оны Өрхийн нийгэм эдийн засгийн судалгааны дэд түүвэр (ӨНЭЗС)
- **Түүврийн хэмжээ, хамрагдалтын хувь:** 1147 өрх, 94.6 хувь (хоёр дахь шатны судалгаанд хамрагдсан 1212 өрхөөс)
- **Судалгаа авсан дундаж хугацаа:** 15.3 минут
- **Төлөөлөх түвшин:** Улс, хот/хөдөө, суурьшил (УБ/аймгийн төв/сумын төв/хөдөө)
- **Мэдээлэл цуглуулах арга:** Компьютерийн тусламжтайгаар утсаар ярилцлага хийх (CATI)
- **Түүврийн жин:** К.Химелейн (2014)¹ аргачлалын дагуу судалгааны түүврийн жинг тооцсон.

	I	II	III
Мэдээлэл цуглуулсан хугацаа	2020.05.20-29	2020.08.31-09.07	2020.12.03-15
Судалгаанд хамрагдсан хүний тоо	1333 өрх	1212 өрх	1147 өрх
Хамрагдалтын хувь	66.7 хувь (ӨНЭЗС-нд 2018 онд хамрагдсан өрхүүдээс дэд түүвэр хийсэн 2000 өрхөөс)	90.9 хувь (Эхний шатны судалгаанд хамрагдсан 1333 өрхөөс)	94.6 хувь (Хоёр дахь шатны судалгаанд хамрагдсан 1212 өрхөөс)



Ковид-19-ийн халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор нийгмээс тусгаарлах арга хэмжээг хүлээн зөвшөөрөх

- Бүх нийтийн бэлэн байдал буюу хөл хорионы үед бараг бүх хүн өөрсдийгөө болон бусдыг Ковид-19-өөс хамгаалах, халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор нийгмээс тусгаарлагдах арга хэмжээнд орсон.
 - Судалгаанд оролцогчид бараг бүгд байнга маск зүүж, гараа угааж байгаа гэж хариулсан.
 - Судалгаанд оролцогчдын 97 хувь нь гар барин мэндлэх, 96 хувь нь олон хүн цугласан үйл ажиллагаанд оролцохоос татгалзсан.
 - 87 хувь нь хүнсний дэлгүүр явах тоогоо багасгаж, гурван өрх тутмын хоёр нь хүнсний бүтээгдэхүүнийг ердийн хэрэгцээнээсээ их хэмжээгээр нөөцлөөгүй байна.
 - Гурван хариулагч тутмын хоёр нь (11 сарын 12) хөл хорионы улмаас ямар нэгэн аяллын төлөвлөгөөгөө цуцалжээ.
 - Хот, хөдөө болон ядуу, ядуу бус хүмүүсийн хооронд эдгээр зан үйлд мэдэгдэхүйц ялгаа харагдсангүй.






Ковид-19 вакцин хийлгэх хүсэл

- **Нийт судалгаанд оролцогчдын 80 хувь нь вакцин үнэ төлбөргүй хийлгэх, 61 хувь нь төлбөртэй байсан ч хийлгэх хүсэлтэй байна.**
 - Ковид-19-ийн баталгаатай вакциныг хийлгэх хүсэл хотын хүмүүстэй харьцуулахад хөдөө орон нутгийн хүмүүст их байна.
 - Ядуу хүмүүсийн 86 хувь нь вакциныг үнэ төлбөргүй хийлгэх хүсэлтэй байна. Гэхдээ вакцин үнэ төлбөртэй байсан ч хийлгэх тэдний хүсэл нь ядуу бус хүмүүсийнхтэй ижил байна.
- **Хүмүүс ойролцоогоор 25000 орчим төгрөгийг Ковид-19 вакцин хийлгэхэд зарцуулж чадна гэж хариулжээ.**
 - Улаанбаатар хотод амьдардаг болон ядуу бус хүмүүс вакцин тариулахад арай илүү мөнгө зарцуулах боломжтой гэж (27-30 мянган төгрөг) харин хөдөө орон нутгийн болон ядуу иргэд их мөнгө зарцуулах боломжгүй (19-20 мянган төгрөг) гэж хариулсан байна.
- **Ковид-19 вакцины баталгаатай эсэх, даган гарах гаж нөлөөний талаарх санаа зовнил нь хүмүүсийн вакцинд хамрагдах хүсэл эрмэлзлэлийг бууруулж байна.**

КОВИД-19 вакцин хийлгэх сонирхолтой иргэдийн хувь, төлбөрийн хэлбэрээр, хувиар



Иргэдийн вакцин хийлгэх боломжтой дундаж зардал болон хугацаа



Вакцин хийлгэхгүй байх эсвэл хийлгэхдээ итгэлтэй биш байгаа шалтгаан, хувиар






Ковид-19 вакцин хийлгэх зорилтот бүлгүүд

- Судалгаанд оролцогчид Ковид-19 вакцинд хамрагдах тэргүүн шугамын хүмүүс буюу зорилтот бүлгийг эмч, эмнэлгийн ажилтнууд болон өндөр настангууд гэж үзсэн.
 - Хамгийн тэргүүн эгнээнд вакцинд хамрагдах хүмүүсийг эмч, эмнэлгийн ажилтнууд (60%) ба өндөр настангууд (55%) дараа нь цэрэг, цагдаагийн албан хаагчид (41%) болон хүүхдүүд (35%) гэж хариулсан байна.
 - Хариулагчид халдвар авах өндөр эрсдэлтэй ажлын байр болон өндөр настангуудад илүү ач холбогдол өгч байна. Тэд ядуу байх нь тэргүүн шугаманд вакцинд хамрагдах чухал хүчин зүйл гэж үзэхгүй байна.

Иргэдийн бодлоор вакциныг хамгийн түрүүнд хийх гол зорилтот бүлгийн хүмүүс, хувиар (Хариулагч бүр гурван бүлгийн хүмүүсийг сонгосон)





Хөдөлмөр эрхлэлт: Цар тахлын үеийн ажил зогсолт (1)


Цар тахлаас өмнө ажил эрхэлж байсан хүн амын 37 хувь нь хөл хорионы үед (11 сарын 12-ноос хойш) ажлаа зогсоосон байна. Гэхдээ тэдний 5 хүн тутмын 3 нь хөл хорио суларсны дараа ажилдаа эргэж орно гэж хариулсан.

- Цар тахлаас өмнө ажил эрхэлж байсан хүмүүсийн 81 хувь нь эхний шатны судалгааны үед ажлаа хийж харин 19 хувь нь ажил эрхлэхээ больсон байв.
- Эхний шатны судалгааны үед ажил эрхэлж байсан хүмүүсийн 45 хувь нь гурав дахь шатны судалгааны үед үргэлжлүүлэн ажиллаж байсан байна. Харин тэдний 37 хувь нь ажил хийхээ зогсоосон байжээ.
- Гурав дахь шатны судалгааны үед ажил эрхлэхээ зогсоосон хүмүүсийн (37 хувь) 61 хувь нь хөл хорионы дараа ажилдаа эргэж орно гэжээ. Энэ шатны судалгааны үед ажил эрхлэхээ зогсоосон хүмүүсийн талаас илүү хувь нь Ковид-19-ээс шалтгаалан хязгаарлалт хийсэн, хаасны улмаас ажил эрхлэхээ түр зогсоосон гэж хариулсан байна.
- Цар тахлаас өмнө ажил эрхлээгүй байсан хүмүүсийн 15 хувь нь гурав дахь шатны судалгааны үед ч мөн ажил эрхлээгүй хэвээр байв. Харин цар тахлаас өмнө ажил эрхлээгүй байсан хүмүүсийн 4-хөн хувь нь гурав дахь шатны судалгааны үед ажилд орсон нь цар тахлын үед ажил олох нь бэрхшээлтэй байгааг харуулж байна.

Хөдөлмөр эрхлээгүй гол шалтгаан, хувиар
(1-р шатанд хөдөлмөр эрхэлдэг байсан ба 3-р шатанд хөдөлмөр эрхлээгүй байсан)



1, 3 дахь шат хоорондын хөдөлмөр эрхлэлтийн өөрчлөлт, хувиар (Цар тахлаас өмнө хөдөлмөр эрхэлж байсан хүн амын хувьд тооцсон)



Тэмдэглэл: Цар тахлаас өмнө ажил эрхэлж байсан хариулагчдын мэдээллийг үндэслэн үе шат бүрт ижилхэн оролцогчдын хувьд тооцсон болно. (Нийт=720)




Хөдөлмөр эрхлэлт: Цар тахлын үеийн ажил зогсолт (2)

Хамгийн бага хэрэглээтэй 40 хувь болон хамгийн их хэрэглээтэй 60 хувийн ажиллагсдын нэлээд хэсэг нь 1-ээс 3 дахь шатны судалгааны хооронд ажил эрхлэхээ зогсоосон байв.

- Доод 40 болон дээд 60 хувьд багтсан ажиллагсдын 32-оос 39 хувь нь энэ шатны судалгааны үед ажил эрхлэхээ зогсоосон байна.
- Ажлаа зогсоосон ажиллагсдын дийлэнх хэсэг нь хөл хорионы дараа эргэн ажилдаа орно гэж хариулжээ. Бага хэрэглээтэй 40 хувийн ажиллагсдын 58 хувь нь их хэрэглээтэй 60 хувийн ажиллагсдын 63 хувь нь хөл хорионы дараа ажилдаа эргэж орохоор байна.

Цар тахлаас өмнө ажил эрхэлж байсан хамгийн бага хэрэглээтэй 40 хувийн ажиллагсдын дөрөвний нэг нь эхний шатны судалгааны үед л ажил эрхлэхээ зогсоосон байсан нь амьжиргаа муутай ажилчин анги урт хугацаанд ажлын байргүй болсныг илэрхийлж байна.

- Дээд 60 хувийн 15, доод 40 хувийн 26 хувь нь эхний шатны судалгааны үед ажил эрхлэхээ зогсоосон байжээ.
- Доод 40 хувийн ажиллагсдын 5 хувь нь л гурав дахь шатны судалгааны үед ажилд орсон байсан ба үлдсэн 21 хувь нь ажилгүй хэвээр байв.





Хөдөлмөр эрхлэлт: Цар тахлын үеийн ажил зогсолт (3)

Цар тахал эхэлснээс хойш үйлдвэрлэлийн салбарын ажиллагчид ажлын байраа алдагчдын (ажлаа зогсоосон) хамгийн их хувийг эзэлж байна.

- Эхний шатны судалгааны үед тэдний дөрөвний гурав нь (74 хувь) ажил эрхэлж байсан бол гурав дахь шатны судалгааны үед зөвхөн 29 хувь нь ажиллаж байжээ.
 - Үйлдвэрлэлийн салбарын ажиллагсдын бараг тал хувь нь (48 хувь) 1-ээс 3 дугаар шатны хооронд ажил эрхлэхээ зогсоосон байна. Үлдсэн 23 хувь нь 1 дүгээр сарын сүүлээс эхний шатны судалгааны хооронд ажил эрхлэхээ зогсоосон бөгөөд гурав дахь шатны судалгааны үед ч ажил эрхлээгүй байв.


Үйлчилгээний салбарт ажиллагсдын нэлээд хувь нь хатуу хөл хорионы үеэр (11 дүгээр сарын 12-ноос) ажил эрхлэхээ зогсоожээ.

- Үйлчилгээний салбарт ажиллагсдын 78 хувь нь эхний шатны судалгааны үед ажил эрхэлж байсан бол гурав дахь шатны судалгааны үед зөвхөн 49 хувь нь ажиллаж байв.

Хөдөө аж ахуйн хөдөлмөр эрхлэгчид цар тахлын нөлөөнд харьцангуй бага өртсөн хэдий ч гурав дахь шатны судалгааны үед тэдний 3 хүн тутмын 1 нь ажил эрхлэх боломжгүй байжээ.

- Эхний шатны судалгааны үед тэдний 96 хувь нь ажил эрхлэх боломжтой байсан бол гурав дахь шатны судалгааны үед 67 хувь нь ажил эрхэлж 3 хүн тутмын 1 нь хөдөлмөр эрхлэх боломжгүй болсон байна.

1, 3 дахь шат хоорондын хөдөлмөр эрхлэлтийн өөрчлөлт, салбараар



Цар тахлаас өмнө хөдөлмөр эрхэлж байсан хүн амын хувь

- I болон III шатанд ажилласан
- I шатанд ажиллаагүй, III шатанд ажилласан
- I шатанд ажилласан, III шатанд ажиллаагүй
- I болон III шатанд ажиллаагүй
- III шатанд ажилласан




Хөдөлмөр эрхлэлт: Өрхийн бизнес (1)

Өрхийн бизнес эрхэлдэг өрхүүдийн 85 хувь нь ЗГ-аас тогтоосон хөл хорионы улмаас гурав дахь шатны судалгааны үед бизнес эрхлэх боломжгүй байв.

- Өрхүүдийн 23 хувь нь гурав дахь шатны судалгааны үед бизнес эрхэлж байв.
- Хоёр дахь шатны судалгааны үед өрхүүдийн дийлэнх нь (78 хувь) бизнесээ эрхлэх боломжтой байсан бол гурав дахь шатны судалгааны үед зөвхөн 15 хувь нь бизнесээ эрхэлж байсан. Үлдсэн 85 хувь нь ЗГ-аас тогтоосон хөл хорионы улмаас хагас цагаар ажиллаж эсвэл бизнесээ зогсоосон байна.

Бизнесээ зогсоосон байдал хот суурин газар болон үйлчилгээний салбарт илүү байна.

- Бизнес эрхэлдэг өрхүүд ерөнхийдөө хот суурин газар болон үйлчилгээний салбарт төвлөрч байдаг тул эдгээр байршил, салбарт бизнес хаагдах нь илүү ажиглагддаг. Гурав дахь шатны судалгааны үед бизнесээ зогсоосон өрхүүдийн 86 хувь нь нийслэл хот болон аймгийн төвд, 81 хувь нь үйлчилгээний салбарт бизнес эрхэлдэг байна.




Тэмдэглэл: (1) Зөвхөн панел өрхүүдийн хувьд тооцсон болно.



Хөдөлмөр эрхлэлт: Өрхийн бизнес (2)

Өрхүүдийн бизнесийн орлого ба хэтийн төсөөлөл нь 3 дахь шатанд илүү муудсан байна.

- Бүх нийтийн бэлэн байдал буюу хөл хорио нь бизнесийн орлогын алдагдлыг хоёр дахь шатны үетэй харьцуулахад улам бүр дордуулсан.
 - Хагас цагаар болон бүтэн цагаар хэвийн ажиллаж байгаа өрхийн бизнес эрхлэгчдийн 90 орчим хувь нь 2019 оны 11 сартай харьцуулахад орлого нь буурсан гэжээ.
 - Өнгөрсөн оны 11 сартай харьцуулахад орлого буурсан гэж хариулагчдын 27 хувь нь огт орлогогүй болсон 30 орчим хувь нь 60-аас дээш хувиар орлого алдсан гэж хариулсан байна.
 - Орлого алдсан гол шалтгаан нь Ковид-19-өөс шалтгаалсан хөл хорио (70%), үйлчлүүлэгчийн тоо цөөрсөн (15%) байна.
- Хөл хорио нь бизнесийн төсөөлөлд ч бас нөлөөлсөн байна. Хоёр дахь шатны судалгааны үед 3 өрх тутмын 1 нь ирэх саруудад бизнесийн орлого буурна гэж хариулж байсан бол гурав дахь шатны судалгаанд 3 өрх тутмын 2 нь 2021 оны 1-3 сард орлого буурна гэж үзжээ.






Хөдөлмөр эрхлэлт: Хөдөө аж ахуй


Хөдөө аж ахуйн хөдөлмөр эрхлэгчид бизнес эрхлэгчидтэй харьцуулахад цар тахлын нөлөөнд арай бага өртөж байгаа хэдий ч хоёр гурав дахь шатны судалгааны хооронд өрхүүдийн амьжиргаа дордсон байна.

- Хоёр болон гурав дахь шатны судалгааны хооронд нийт өрхийн ойролцоогоор 18 хувь нь хөдөө аж ахуйн хөдөлмөр эрхэлж байв.
- Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад орлого буурсан гэж 5 өрх тутмын 3-аас илүү нь хариулжээ.
 - Тэдний орлогын алдагдал хоёр дахь шатны судалгааны үетэй харьцуулахад илүү нэмэгдсэн байна. Хоёр дахь шатанд орлого буурсан гэж хариулсан өрхүүдийн 44 хувь нь орлогоо 40-өөс дээш хувиар алдсан гэж хариулж байсан бол гурав дахь шатанд энэ хувь 57 болсон байна.
 - Мал аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэл өвлийн саруудад харьцангуй бага байдаг бөгөөд гурав дахь шатны судалгааны үед сүүний үйлдвэрлэл үндсэн үйл ажиллагаа нь байв. Сүүний үйлдвэрлэл эрхлэгчдийн талаас илүү хувь нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад үнэ болон үйлдвэрлэж буй хэмжээ бага байгаад санаа зовниж байгаагаа илэрхийлжээ.

ХАА-н орлогын байдал (Өмнөх оны мөн үетэй харьцуулснаар)



ХАА-н орлогын бууралтын хувь




ХАА эрхэлдэг өрхийн 57 хувь нь 40, түүнээс их хувиар орлогоо алдсан байна.



Хөдөлмөр эрхлэлт: Цалинтай ажил

Бүх нийтийн бэлэн байдал буюу хөл хорио цалинтай хөдөлмөр эрхлэгчдэд мөн нөлөөлсөн. Ердийнхөөрөө хэвийн ажиллаж чадаагүй цалинтай хөдөлмөр эрхлэгчдийн ойролцоогоор тал нь цалингаа бүтнээр эсвэл хэсэгчлэн авсан байв.

- Хоёр дахь шатны судалгааны үед цалинтай хөдөлмөр эрхлэгчдийн 90-ээс дээш хувь нь ердийнхөөрөө хэвийн ажиллаж байв. Харин гурав дахь шатны судалгааны үед буюу хөл хорионы үед ойролцоогоор 30 орчим хувь нь хэвийн ажиллах боломжгүй болсон.
- Хэдийгээр зарим хүмүүс ердийнхөөрөө хэвийн ажиллаагүй ч гэсэн тэдний 18 хувь нь цалингаа бүтнээр, 30 хувь нь цалингаа хагасалж авахаар байв.
- Сүүлийн 3 сарын байдлаар цалинтай хөдөлмөр эрхлэгчдийн 71 хувийнх нь цалин өөрчлөгдөөгүй хэвээрээ, харин 26 хувийнх нь цалин буурсан байжээ.
- Хотын болон ядуу цалинтай хөдөлмөр эрхлэгчид сүүлийн 3 сард цалингийн орлогоо илүү алдсан байна.






ХҮНДРЭЛ, БЭРХШЭЭЛИЙГ ДАВАН ТУУЛЖ БУЙ БАЙДАЛ (1)


Ерөнхийдөө 5 өрх тутмын 3 нь ямар нэг төрлийн хүндрэл бэрхшээлтэй тулгарсан бөгөөд тэдний талаас илүү хувь нь хөл хорионы үед хүнсний гол нэрийн барааны үнэ нэмэгдсэн бэрхшээлд өртсөн талаар мэдээлсэн байна.

- Ялангуяа ядуу өрх (68%) ядуу бус өрхүүдтэй (58%) харьцуулахад илүү бэрхшээлд өртсөн байдалтай байна.
- Мөн түүнчлэн ядуу өрх (61%) ядуу бус өрхүүдтэй харьцуулахад (48%) хүнсний бүтээгдэхүүний үнийн өсөлтөд илүү нэрвэгдсэн байна.
- ХАА-н бус бизнесээ хаалгасан бэрхшээл хөдөөтэй (5%) харьцуулахад хотод (17%) илүү байна.
- ХАА-н болон ХАА-н бус үйлдвэрлэл, үйлчилгээний бүтээгдэхүүний үнэ унасан бэрхшээлд өртсөн гэж хөдөө, орон нутгийн өрхүүдийн 14 хувь нь хариулжээ.

2020.11.12-ноос хойш ямар нэгэн хэлбэрийн хүндрэл бэрхшээлтэй тулгарсан өрхийн хувь



2020.11.12-ноос хойш хүндрэл бэрхшээлд өртсөн өрхийн хувь, бэрхшээлийн төрлөөр






ХҮНДРЭЛ, БЭРХШЭЭЛИЙГ ДАВАН ТУУЛЖ БУЙ БАЙДАЛ (2)


- **Суурьшил, орлогын байдлаасаа хамааран хүмүүс хүндрэл бэрхшээлийг өөр өөр аргаар даван туулж байна.**
 - Хүндрэл бэрхшээлийг даван туулж буй хот, суурин газрын болон ядуу өрхүүд хүнс, хүнсний бус хэрэглээгээ танах хандлага илүү байгаа бол хөдөө, орон нутгийн болон ядуу бус өрхүүд санхүүгийн байгууллагаас зээл авах, зээлээр худалдан авалт хийх хандлагатай байна.
- **Гэтэл нөгөө талд нийт бэрхшээлд өртсөн 5 өрх тутмын 2 нь хүндрэл бэрхшээлээс гарах ямар ч арга хэмжээ аваагүй байна.**

Өрхийн хүндрэл, бэрхшээлийг даван туулсан байдал (олон хариулттай)

Ядуурлын байдлаар





Хот, хөдөөгөөр





Өрхийн хүнсний баталгаат байдал

- Бүх нийтийн бэлэн байдалд шилжсэн буюу хөл хорио эхэлснээс хойш хүнсний бүтээгдэхүүний үнэ өссөн байна.
 - 2020 оны 11 сард хүнсний ХҮИ өмнөх оны мөн үеэс 8 хувиар өсчээ.
- Хүнсний аюулгүй байдлын үзүүлэлтүүд болох хангалттай, эрүүл, шим тэжээлтэй хоол хүнсээр хангагдсан байдал 8 сарын үеэс (хоёр дахь судалгааны үе) бага зэрэг дордсон байна.
- Ялангуяа, ядуу иргэдийн хүнсний аюулгүй байдал доройтсоор байна.
 - Гурав дахь шатны судалгаанд ядуу хүмүүсийн бараг тал хувь нь (i) хангалттай хоол хүнс (ii) эрүүл, шим тэжээлтэй хоол хүнс (iii) олон төрлийн хоол хүнс олж авах чадвартаа эргэлзсэн хэвээр байна. Энэ хувь хоёр дахь шатны судалгааны үед 40 орчим байсан юм.




Тэмдэглэл: Ядуурлын байдлыг 2018 оны ӨНЭЗС-ны дүнд үндэслэв. Зөвхөн гурван шатны судалгаанд гурвууланд нь хамрагдсан өрхүүдийн мэдээлэлд үндэслэн тооцсон (1147 өрх).




Санаа зовнилт

- **Ядуу болон хангалттай хоол хүнсний нөөцгүй өрхүүдийн нэлээд хэсэг нь ирэх өдрүүдийнхээ хүнсний хангамж, санхүүдээ санаа зовнисон байдалтай байна.**
 - Ирэх 7 хоногийнхоо хүнсний хангамжид санаа зовж байгаагаа ядуу өрхүүдийн 30 хувь, хангалттай хоол хүнсний нөөц байхгүй үе байсан гэж хариулсан өрхүүдийн 46 хувь нь илэрхийлсэн.
 - Хүнсний аюулгүй байдал алдагдсан өрхүүдэд санхүүгийн асуудал нь илүү сэтгэл түгшээсэн байдалтай байна. Хангалттай хоол хүнсний нөөц байхгүй үе байсан гэж мэдээлсэн өрхүүдийн талаас илүү хувь нь ирэх сарынхаа санхүүд маш их санаа зовсон, 24 хувь нь тодорхой хэмжээгээр санаа зовсон байдалтай байна.
- **Энэ шатны судалгааны үед эхний хоёр шатны судалгааны үетэй харьцуулахад өрхүүд ирэх сарын санхүүгийн байдалдаа санаа зовох нь ихэссэн байв.**
 - Эхний хоёр шатанд нийт өрхийн санаа зовнилтын хувь 37-40 байсан бол энэ шатны судалгааны үед 47 хувь болж өссөн.

Ирэх долоо хоногт идэх хангалттай хоол байхгүй гэж санаа зовж буй байдал, хувиар



Ирэх сарын өрхийнхөө санхүүд санаа зовж буй байдал, хувиар






Тусламж дэмжлэг: Нийгмийн халамж (1)


Хүүхдийн мөнгө хөтөлбөрт ядуу өрхүүд (84%) сайн хамрагддаг. Гэвч өнөөгийн нөхцөлд (өрхүүдийн хүнсний баталгаат байдлыг анхаарах шаардлагатай үе) зөвхөн зорилтот өрхүүдэд хүүхдийн мөнгийг чиглүүлнэ гэдэг бэрхшээлтэй хэвээр байна.

- Судалгааны дүнгээс харахад ядуу өрхийн 84 хувь нь, ядуу бус өрхийн 60 хувь нь 3 сараас хойш хүүхдийн мөнгө авсан байна.
- Хоол хүнс хүрэлцэхгүй нь гэж санаа зовж байсан өрхүүдийн бараг 30 хувь нь хүүхдийн мөнгө хөтөлбөрт хамрагдаагүй байв. Түүнчлэн ядуу өрхүүдийн 21 хувь нь хүнсний талон авсан байхад хоол хүнс нь хүрэлцэхгүй гэж санаа зовнилт байсан өрхүүдийн 11 хувь нь л хүнсний талонд хамрагджээ.
- Өрхүүдийн ЗГ-аас авч байгаа тусламж, дэмжлэгийн мөнгөн дүн хоёр дахь судалгааны үеэс өөрчлөгдөөгүй байна. Өрхүүдийн хамгийн ядуу 20 хувь сүүлийн сард дунджаар 259000 төгрөгийн хүүхдийн мөнгө авсан ба энэ нь цар тахлын өмнөх тэдний орлогын 40%-тай тэнцэж байна.⁽¹⁾ Тэд нийтдээ сард дунджаар 331000 төгрөгний тусламж, дэмжлэгийг ЗГ-аас хүлээн авсан нь цар тахлын өмнөх тэдний орлогын 52%-тай тэнцэж байна.

Нийгмийн хамгааллын хөтөлбөрийн хамралт, хувиар (2020 оны 3-н сараас хойш шилжүүлэг хүлээн авсан өрхийн хувьд)



Цар тахлын өмнөх өрхийн орлогод ЗГ-ын тусламж, дэмжлэгийн эзлэх хувь





Тэмдэглэл: Ядуурлын байдлыг 2018 оны ӨНЭЗС-ны дүнд үндэслэв. (1) Цар тахлаас өмнөх өрхийн дундаж орлогыг (нэрлэсэн) 2018 оны ӨНЭЗС-аас тооцсон.



Тусламж дэмжлэг: Нийгмийн халамж (2)

Хүүхдийн мөнгө хүлээн авсан 3 өрх тутмын 2 нь тухайн мөнгийг шууд хэрэглэсэн эсвэл удахгүй авч хэрэглэнэ гэж хариулсан ба тухайн мөнгийг ихэвчлэн хоол, хүнсний зүйл худалдан авахад зарцуулсан байв.

- Хүүхдийн мөнгө авсан 3 өрх тутмын 2 нь тухайн мөнгийг шууд хэрэглэсэн эсвэл удахгүй авч хэрэглэнэ гэж хариулсан бол 3 өрх тутмын 1 нь хожим хэрэглэхээр төлөвлөж хадгалсан гэжээ. Ялангуяа хоол, хүнс хүрэлцэхгүй нь гэж санаа зовниж байсан 4 өрх тутмын 3 нь хүлээж авсан хүүхдийн мөнгөө шууд хэрэглэсэн эсвэл удахгүй авч хэрэглэнэ гэж хариулсан байна.
- Харин хүнсний талон авсан өрхүүдийн 81 хувь нь шилжүүлгийг тэр дор нь ашигласан байв.
- Хүүхдийн мөнгийг хүлээн аваад шууд хэрэглэсэн өрхүүдийн 76 хувь нь хоол, хүнсний зүйл худалдан авахад зарцуулсан байна.
- ЗГ-аас үзүүлж буй тусламж, дэмжлэг нь цар тахлын өрхийн амьжиргаанд үзүүлж буй сөрөг нөлөөг бууруулахад тус нэмэр болсон байв.
 - Хүүхдийн мөнгө авсан өрхүүдийн 81 хувь нь сөрөг нөлөөг тодорхой хэмжээгээр бууруулсан гэжээ.
 - Харин хүнсний талон авсан өрхүүдийн 31 хувь нь сөрөг нөлөөг бүрэн бууруулсан, 68 хувь нь тодорхой хэмжээгээр бууруулсан гэж хариулсан байна.






Боловсрол (1)


Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан 11 дүгээр сарын 12-ноос бүх сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагааг зогсоосон. Сургуульд суралцаж байсан хүүхдүүдтэй бараг бүх өрх (97%) хатуу хөл хорионы үед зайн сургалтын үйл ажиллагаанд хамрагдсан ба дийлэнх нь зурагтаар нэвтрүүлсэн боловсролын хөтөлбөрт хамрагдсан байв.

- Хот, суурин газрын сургуулийн насны хүүхэдтэй өрх бүр (99%) сурах үйл ажиллагаанд оролцсон бол хөдөөд энэ хувь ялимгүй доогуур (91%) байна.
- Сургалтын хамгийн түгээмэл үйл ажиллагаа нь зурагтаар боловсролын нэвтрүүлэг үзэх (94%), багшийн өгсөн даалгаврыг хийх (43%), онлайнаар багшаас сургалт авах (33%) байна.
 - Хотын хүүхдүүдийн 36 хувь нь онлайнаар багшаас сургалт авсан байхад хөдөөд энэ хувь 26 байна.

Өнгөрсөн 7 хоногт ЕБС-ийн боловсролын сургалтын үйл ажиллагаанд хамрагдсан хүүхэдтэй өрхийн хувь



Өнгөрсөн долоо хоногт хүүхдийн (хүүхдүүдийн) хамрагдсан боловсролын сургалтын үйл ажиллагаа, төрлөөр, хувиар







Боловсрол (2)

- **Дийлэнх хүмүүс зайн сургалтын үйл ажиллагаанд сэтгэл хангалуун (74%) байгаа бол 5 хүн тутмын 1 нь сэтгэл хангалуун бус байна.**
 - Гэхдээ хүмүүсийн сэтгэл ханамжийн түвшин эхний судалгааны үетэй харьцуулахад буурсан. Тухайлбал, эхний хөл хорионы үед буюу эхний судалгааны үед зайн сургалтын үйл ажиллагаанд огт хангалуун бус гэж хариулсан хүмүүсийн хувь 7 байсан нь энэ шатанд 13 болж өссөн байна.
 - Хүүхдүүдийн багштайгаа холбоо барих арга хот, хөдөөд ялгаатай байна. Хөдөөд 4 хүүхэд тутмын 3 нь багштайгаа шууд утсаар ярьж холбогддог байхад хотод дийлэнх нь фэйсбүүк ашиглан холбогдсон байжээ.
- **Хүүхдүүдийн сурч боловсрох үйл ажиллагаанд цахим төхөөрөмж ашиглах боломж нь нөлөөлсөөр байна.**
 - Улсын хэмжээнд авч үзвэл зурагт хамгийн өргөн ашиглагддаг сургалтын хэрэгсэл байна. Харин хөдөөгийн болон ядуу өрхийн хүүхдүүд компьютер, таблет, ухаалаг утас ашиглах боломж харьцангуй багатай байна.


Өнгөрсөн 7 хоногт нэвтрүүлсэн сургалтын үйл ажиллагааны чанар, хэрэгжилтийн талаарх сэтгэл ханамж



Хүүхдүүдийнхээ багштай багштай холбоо барьсан арга, төрлөөр, хувиар



Хүүхэд суралцахад хэрэгтэй цахим төхөөрөмжтэй өрхийн хувь (сургуульд суралцдаг хүүхэдтэй өрхийн хувьд)





Эрүүл мэнд, санхүүгийн үйлчилгээний хүртээмж

- Хөл хорионы үе буюу гурав дахь шатны судалгааны үед эмчилгээ шаардлагатай болсон 3 өрх тутмын 1-ийнх нь хэн нэг гишүүн эмнэлгийн үйлчилгээ авч чадаагүй байв. Гэтэл эхний шатны судалгааны үед эмчилгээ шаардлагатай болсон бараг бүх өрх (92%) эмнэлгийн үйлчилгээ авсан байна.
 - Эмнэлгийн үйлчилгээ авч чадаагүй үндсэн шалтгаанууд нь эмнэлгээс халдвар авах эрсдэлтэй гэж үзсэн (51%) болон гэрээс гадагш гарахыг хязгаарласан/хориглосон (22%) байна.
- Нөгөөтэйгүүр, санхүүгийн үйлчилгээний хүртээмжид ноцтой өөрчлөлт гараагүй байв.
 - Санхүүгийн үйлчилгээ шаардлагатай болсон хүмүүсийн 92 хувь нь үйлчилгээгээ амжилттай авчээ.

